

## Цагдан Сэргийлэх хэлтэс

1940-10-4-энд, 1950-6-2, 1957-6-17, 1960-3-31, 1966-10-5-анд сайд нарын Зөвлөлийн 38, 135, 278, 142, 354-р тогтоолуудаар БНМАУ-ын хот суурингийн гудамж, замын хөдөлгөөний дүрмийг тус тус шинэчлэн баталж дагаж мөрдөж иржээ.

1941-оны 8-р сард цагдан сэргийлэх ажилд туслах сайн дурын бригад байгуулагдан ажилласан ба дүрмийг баталсан нь олон нийтээс, сэргийлэх байгууллагын ажилд бие дааж оролцох анхны үүсэл нь байжээ.

1960-4-6-нд Сайд нарын Зөвлөлийн 163 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын оршин суугч тус улсын харьяат бүх иргэдийн түр паспортыг БНМАУ-ын иргэний паспортаар сольж олгох ажлыг 1960-4-45-нас 6 дугаар сарын 15-ний дотор хийж дуусгахаар тогтоожээ.

1960 онд сэргийлэхэд туслах сайн дурын бригадыг залуучуудын 5,10-тын бригадуудтай нэгтгэж цагдан сэргийлэхэд туслах хамт олны бригад болгон шинэчилсэн байна. 1968-2-2-онд Сайд нарын Зөвлөлийн 34-р тогтоолоор Улаанбаатар хотод согтуурагчдыг эрүүлжүүлэх байрыг 1968 онд байгуулахаар тогтоожээ.

1974-12-13-анд сайд нарын Зөвлөлийн 513 дугаар тогтоолоор БНМАУ-ын бүх иргэдийг паспортлуулах, паспортыг шинэчлэн солих ажлыг 1977 онд явуулахаар заажээ.

1974-12-27-онд Сайд нарын Зөвлөлийн 559 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын районуудад гудамж, орон сууц хариуцсан хэсгийн байцаагч бий болгожээ.